

БАТЛАВ.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Ч. УНДРАМ

**ОРГАНИК БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН  
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

**1.1.Хууль зүйн үндэслэл**

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтооолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.3.10-т "Мал, малын гаралтай түүхий эдийг боловсруулах байгальд ээлтэй цогцолбор байгуулж, хөдөө аж ахуйн гаралтай бараа, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ", 3.3.15-д "Төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурласан, байгаль орчинд ээлтэй, хүлэмжийн хий багатай ногоон төслүүдийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ." 3.3.11-д "Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрт бүтээгдэхүүнээ нийлүүлсэн малчид, тариаланчдад төрөөс урамшуулалт олгоно.", 6.2.13-т "Түүхий эдийн нөөцөд тулгуурлан орон нутгийн онцлогт тохирсон ажлын байр нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих үйлдвэрлэлийг хөгжүүлнэ" гэх зорилтууд;

УИХ-ын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоолын 2-ын г/-д "мал аж ахуй, газар тариалан, хүнсний үйлдвэр, хадгалалт, тээвэрлэлт, худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг мөрдүүлэх, хүнсний сүлжээний үе шат бүрд хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, түүнийг баталгаажуулах эрх бүхий итгэмжлэгдсэн байгууллагын тоог нэмэгдүүлэх;", д/-д "хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн явцад аюулгүйн үзүүлэлтийн шаардлагыг бүрэн хангасан эсэхэд тавигдах дотоодын хяналтыг нэмэгдүүлэх, хөндлөнгийн хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, хяналтын үйл ажиллагааг эрчимжүүлэх;"; з/-д "монгол орны байгаль, газар зүй, цаг уурын онцлогтой уялдсан уламжлалт хүнс бэлтгэх арга технологийг сэргээн таниулах, хэрэглээнд нэвтрүүлэх, хүнс бэлтгэх уламжлалт мэдлэгт сууринсан, инновац шингэсэн бүтээгдэхүүн бий болгох тогтолцоог бүрдүүлэх, дэмжлэг үзүүлэх;"; 5-ын а/-д "мал аж ахуй, газар тариалангаас нийлүүлсэн хүнсний түүхий эдийг дотооддоо боловсруулах, бэлэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, дотоодын зах зээлд борлуулсан чанар, эрүүл ахуй, аюулгүйн үзүүлэлтийн шаардлага хангасан бүтээгдэхүүнд олгож байгаа урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох;"; к/-д "хоол, хүнсний зөв, зохистой,

соёлтой хэрэглээний талаарх сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах" арга хэмжээнүүд;

Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр (2021-2026)-ийн 1.2.4-т "Хүн ардаа эрүүл, аюулгүй хүнсээр бүрэн хангах, мал аж ахуй, газар тариалан, хүнсний үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэх "Органик хүнс экспортлогч улс" үндэсний хөтөлбөрийг санаачилж ажиллана" гэж тус тус заасан нь хөдөө аж ахуйн органик хүнсний сүлжээнд хамаарах эрх зүйн орчныг боловсронгуй болгох эрх зүйн үндэслэл болно.

## 1.2.Практик шаардлага

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2.5-д "Хүнсний хангамж, нийлүүлэлтийн үйл ажиллагаанд тавих эрүүл ахуй, аюулгүй байдлын стандарт, шаардлагыг боловсронгуй болгож, баталгаат хүнсний үйлдвэрлэлийн тогтвортой систем бий болгон органик, баяжуулсан, зохицуулах үйлчилгээтэй болон эрүүл хүнсний хэрэглээтэй болно" гэх, 8.3-т "Нүүдлийн уламжлалт өв соёлыг хадгалсан, экологид ээлтэй, органик мал аж ахуйг тогтвортой эрхлэх, хөдөө аж ахуйн эрчимжсэн үйлдвэрлэлийг төрөлжүүлж, кластер, логистик, санхүүгийн түрээсийн үйлчилгээг хөгжүүлж, төлөвшүүлнэ.", "Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гадаад зах зээлийг тэлж, зарим нэр төрлийн түүхий эд, бүтээгдэхүүний импортыг халж, экспортыг нэмэгдүүлнэ." гэх, 9.2-т "Хүнсний аюулгүй байдлыг хангах, хөдөө орон нутгаас нийлүүлдэг органик хүнсний сүлжээ бий болгоно" гэх зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1-д Монгол Улсын иргэний амьд явах эрхийг хангахад чиглэсэн арга хэмжээнүүдийн нэг юм.

Манай улс 2030 он гэхэд нийт хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний 5 хувийг органик баталгаажуулалтад хамруулах зорилт тавьсан бөгөөд үүнд 2016 онд баталсан Органик хүнсний тухай хууль болон холбогдох эрх зүйн баримт бичгүүдийг баталсан нь органик хүнсний үйлдвэрлэлийн цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлоход чухал алхам болжээ.

Гэвч Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт заасны дагуу Органик хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний дүнгээс хараад органик хүнсний үйлдвэрлэл хөгжихгүй байхад нелөөлж буй хүчин зүйлс нь нэгд, органик үйлдвэрлэлийг төрөөс дэмжих асуудал өнеөг хүртэл нэгдсэн бодлого, төлөвлөлтгүй, тухайн салбарыг хариуцсан төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүрэг тодорхойгүй, асуудал хариуцсан албан тушаалтны тоо хүртээмжгүй зэрэг төрийн бодлого, тогтолцооны шинжтэй, хоёрт, органик анхан шатны үйлдвэрлэл эрхлэгч, боловсруулах үйлдвэрлэл эрхлэгч, хэрэглэгч төдийгүй

баталгаажуулалт, төрийн болон нутгийн захиргааны холбогдох эрх бүхий албан тушаалтан зэрэгт шаардлагатай мэдлэг, мэдээлэл олгох үйл ажиллагаа болон органик үйлдвэрлэл хөгжихөд чухал нөлөөтэй эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүн, инноваци, шинэ технологи нэвтрүүлэх асуудал хангалтгүй, органик бүтээгдэхүүнийг хуурамч бүтээгдэхүүнээс хамгаалах асуудал орхигдсон зэрэг үйл ажиллагаа, зохион байгуулалтын шинжтэй олон асуудал тулгамдаж байгаатай холбоотой байна. Үүнээс шалтгаалан хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын шаардлага хангасан, экологид ээлтэй хөдөө аж ахуйн органик үйлдвэрлэл эрхлэх, органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагаа өнгөрсөн 5 жилийн хугацаанд удаашралтай байсан бөгөөд үүнд органик бүтээгдэхүүний гадаад, дотоодын зах зээлд өрсөлдөх чадвар, үнэлэмж сул, мөн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэх нөхцөлийг сайжруулах ямарваа нэг хөшүүрэг болохуйц үйл ажиллагаа, дэмжлэг, туслалцаа хэрэгжүүлээгүй нь давхар нөлөөлжээ.<sup>1</sup> Иймээс Органик хүнсний тухай хуулийг боловсронгуй болгох замаар хүнсний болон хүнснээс бусад хөдөө аж ахуйн гаралтай органик бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, органик бүтээгдэхүүнийг баталгаажуулах, олон улсын зах зээлд өрсөлдөх боломжийг дээшлүүлэх хэрэгцээ шаардлага үүссэн нь тогтоогджээ.

Монгол орны газар нутаг, хөрс, цаг уурын онцлог нөхцөл байдал нь Монгол Улсыг төлөөлөхүйц ХАА-н органик брэнд бүтээгдэхүүнээр дэлхийн зах зээлд өрсөлдөх боломжийг бурдуулсэн. Иймээс мал аж ахуй, газар тариалан эрхлэгчдийг байгаль орчин, эко систем, хүний эрүүл мэндэд ээлтэй ХАА-н органик үйлдвэрлэл эрхлэх, органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлд төрөөс дэмжих нь хөдөөг хөгжүүлэх, орон нутагт ажлын байр бий болгохоос гадна эрүүл, баталгаатай, шим тэжээллэг хүнсээр хүн амаа хангах нөхцөлийг сайжруулахад чухал нөлөөтэйгөөс гадна НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилт 2030 болон Европын холбоо, Ази номхон далайн бүс нутгуудын орнуудын органик үйлдвэрлэлийг дэмжиж буй чиг хандлагад нийцэх юм.

Иймээс 2016 онд батлагдсан Органик хүнсний тухай хуулийг дэлхийн чиг хандлага, олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн боловсруулж хуулийн төсөлд хөдөө аж ахуйн органик хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхлэгчид, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, хүнснээс бусад төрлийн хөдөө аж ахуйн гаралтай органик бүтээгдэхүүнийг баталгаажуулах, хэрэглэгчийг бэлтгэх, органик бүтээгдэхүүнийг сурталчлах, үйлдвэрлэгчид болон баталгаажуулалт, хяналтын байгууллагуудын ажилтан, албан хаагчдад мэдлэг олгох зэрэг асуудлыг нэмж тусгах замаар органик бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, үйлдвэрлэлийн тогтвортой байдлыг хангах, органик бүтээгдэхүүний зах зээлийг тэлэх, мөн энэхүү тогтолцоог удирдлага, зохион байгуулалт, арга зүйгээр дэмжих чиг үүрэг бүхий төрийн байгууллагын үүрэг, оролцоог тодорхойлох зэрэг асуудлыг тусгах шаардлагатай гэж үзэн хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсрууллаа.

<sup>1</sup> Органик хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлангаас

**Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа,  
хамрах хүрээ**

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төсөлд дараах асуудлыг тусгана.

1/ Органик хүнсний тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан зорилт хэдөө аж ахуйн органик үйлдвэрлэл эрхлэх, органик хүнс, тэжээл, бордоо үйлдвэрлэх, тэдгээрийг баталгаажуулах, худалдах, импортлох, органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээ хэрэглэх, сурталчлахтай холбогдсон харилцаанаас гадна экспорт, сургалт, эрдэм шинжилгээ судалгааг дэмжих, мөн органик мал аж ахуй, тариалан эрхлэгчдэд урамшуулал, дэмжлэг үзүүлэх, органик хүнсний бүртгэл, мэдээллийн цахим сангийн үйл ажиллагааг бусад сангийн үйл ажиллагаатай интеграцилах, эдгээр үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, төрийн байгууллагын бүтэц, чиг үүргийн асуудлыг тусгах практик шаардлага байгаа нь хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээгээр<sup>2</sup> тогтоогдсон тул дээрх асуудлуудыг нэмж тусгана.

2/ Органик хүнсний тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хамрах хүрээг өргөжүүлэх замаар эх орны үйлдвэрлэлийн органик бүтээгдэхүүний төрөл, хэмжээг нэмэгдүүлэх, экспортыг дэмжих шаардлагатай байна. Органик хүнсний тухай хуулийн хамрах хүрээнд багтсан органик мал аж ахуй, тариалангийн гаралтай хүнснээс бусад бүтээгдэхүүн, түүхий эд, тухайлбал, ноос, ноолуур, арьс шир, ноосон утас, малын дайвар бүтээгдэхүүн, гоо сайхан болон уламжлалт эм, бэлдмэл, орц зэргийг органикаар баталгаажуулах, мөн эдгээрийг үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, худалдаалах зэрэг харилцааг зохицуулсан эрх зүйн орчныг бүрдүүлснээр малчид, тариаланчдын энэ төрлийн үйл ажиллагаанаас хүртэх эдийн застийн үр өгөөж нэмэгдэхээс гадна органик бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийн түүхий эдийн нөөцийг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ. Иймээс дээр дурдсан асуудлуудыг хуулийн хамрах хүрээнд нэмж тусгана.

3/ Хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа эрхлэгч малчид, тариаланчид болон боловсруулах үйлдвэрт ажиллагчдын төдийгүй төрийн болон мэргэжлийн байгууллагуудын ажилтан, албан хаагчдын органик аж ахуй эрхлэх, бүтээгдэхүүн боловсруулахтай холбоотой хууль эрх зүйн мэдлэг муу, органик баталгаажуулалт хийлгэсэн ч эдийн засгийн ач холбогдол бага, органик үйлдвэрлэлтэй холбоотой бүртгэл, мэдээллийн ажлыг гүйцэтгэх хүний нөөц, ур чадвар дутмаг асуудал байгаа нь Органик хүнсний тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байхад нөлөөлж байгаа тул

<sup>2</sup> Органик хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлангийн 2.1.1 дэх хэсгээс дэлгэрүүлэн үзнэ үү.

органик үйлдвэрлэлийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэхийн тулд Органик хүнсний тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан нэр томьёоны хэсгийг өргөжүүлж органик аж ахуй, үйлдвэрлэл, бүтээгдэхүүнтэй холбоотой нэр томьёо, үйл ажиллагааг хууль хэрэглэгчдэд ойлгомжтой тодорхойлж, нэмж тусгах нь хуулийг нэг мөр ойлгож хэрэглэхэд дэм болохоор байна. Иймээс органик хүнсний хэрэглээг нэмэгдүүлэх, органик үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор хуулийн 4 дүгээр зүйлд заасан нэр томьёоны тодорхойлолт хэсэгт шаардлагатай нэр томьёог шинээр нэмж тусгана.

4/ Органик хүнсний тухай хуульд заасан үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар, хангах, баталгаажуулалтын байгууллагууд, органик аж ахуй эрхлэгчдэд хүртээмжтэй байдлаар зохин байгуулах бүтэц байхгүй, улсын хэмжээнд 2 мэргэжилтэн уг асуудлыг хариуцаж байгаа нь органик үйлдвэрлэлийг далайцтай хөгжүүлэх боломжгүй байна. Иймээс органик үйлдвэрлэл, бүтээгдэхүүнийг дотоод, гадаадын зах зээлд сурталчлах, гадаад орон, олон улсын байгууллагатай хийх олон улсын худалдааны гэрээ, хэлэлцээрт Монгол Улсын органик бүтээгдэхүүний баталгаажуулалтын схемийг хүлээн зөвшөөрүүлэх, эрдэм шинжилгээ судалгааны ажлын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, олон нийтэд мэдээлэл түгээх, сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах болон хяналт тавих, шалгалт хийх, органик бүтээгдэхүүн, үйлдвэрлэлтэй холбоотой бүртгэл, мэдээлэл хөтлөх, статистик боловсруулалт хийх зэрэг асуудлыг Органик хүнсний тухай хуулийн холбогдох хэсгүүдэд нэмж тусгана.

5/ Органик хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний дүнгээс харахад төрөөс 2030 он хүртэл органик баталгаажуулалтад хамрагдсан ХАА-н бүтээгдэхүүний хэмжээт 5 хувьд хүргэх зорилтын хүрээнд 46,4 мянган литр сүү, 26,3 мянган тонн мах, махан бүтээгдэхүүнийг органик хүнсний баталгаажуулалтад хамруулах наад захын шаардлага үүсэх бөгөөд өнөөдөр 2 мянга орчим литр, 10 гаруй төрлийн органик сүү, сүүн бүтээгдэхүүн, 5 төрлийн мах, махан бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлжээ.<sup>3</sup> Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээгээр органик хүнсний бүртгэл, мэдээлэл хөтлөх, мөн цаашид төрөөс баримталж буй бодлогын хүрээнд ХАА-н органик хүнсний үйлдвэрлэл тэлж, олон гишүүнтэй эсхүл цөөн гишүүнтэй хэд хэдэн нөхөрлөл нэгдэн ХББ байгуулах зэрэг тохиолдолд эрх зүйн орчин хангалтгүй зэрэг асуудал байгааг тогтоожээ. Иймд органик бүтээгдэхүүнийг оролцооны аргаар баталгаажуулах баталгаажуулалтын байгууллагуудын тоо өсөн нэмэгдэх хэрэгцээ шаардлагад үндэслэн эдгээр байгууллагуудын бүтэц, үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай тул хуулийн 10 дугаар зүйлд заасан хамтын баталгаажуулалтын байгууллагыг үүсгэн байгуулах, түүнийг төрийн эрх бүхий байгууллага бүртгэх, бүртгэлийн хүчинтэй хугацаа, бүртгэлийг цуцлах зэрэг харилцааг тодорхойлсон эрх зүйн зохицуулалтыг нэмж тусгана.

6/ Дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, үер усны аюул, ган гачиг, цөлжилт, органик бус тариалангийн тэлэлт, шинэ төрлийн хортон шавж, өвчин эмгэг гээд олон хүчин зүйлээс

<sup>3</sup> Органик хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлангийн 2.1.2 дахь хэсгээс дэлгэрүүлэн үзнэ үү.

шалтгаалан бэлчээр, усны хомсдол үүсэж байгаагаас гадна манай улсын мал аж ахуй, тариалангийн талбайн дийлэнх хэсэг нь хүн амын нягтаршил өндөртэй, уул уурхай, аж үйлдвэр эрчимтэй хөгжиж буй бус нутгуудад оршдог, органик аж ахуйтай зэрэгцээ органик бус тариалан, уул уурхай зэрэг органик үйлдвэрлэлд харш үйл ажиллагаа эрхлэх боломжтой зэрэг нь органик мал аж ахуй, тариаланг тогтвортой эрхлэхэд хүндрэл үүсгэх эрсдэлтэй байна.<sup>4</sup> Иймээс ХАА-н органик хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдээр олон улсын зах зээлд өрсөлдөх, экспортыг нэмэгдүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд бус нутаг, аймаг, сумын хэмжээнд уул уурхай, органик бус тариалан, МАА-гаас ангид, хортон шавж, ургамалтай зөвхөн органик аргаар тэмцдэг хууль тогтоомжийн шаардлага хангахуйц хязгаарлалт тогтоосон органик МАА, газар тариалангийн бус бий болгох, мөн органик хүнсний ногооны баталгаажуулалтыг баталгаажсан тариалангийн талбайтай нь холбож баталгаажуулах тухай зохицуулалтыг хуулийн төсөлд нэмж тусгана.

7/ Хэдийгээр манай улс органик хүнсний үйлдвэрлэлийг дэмжих бодлого баримталж байгаа боловч уг бодлогыг хэрэгжүүлэх, энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэх идэвх, санаачилгыг хөхиүлэн дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээ тодорхойгүй байна. Тухайлбал, органик аж ахуй эрхлэгч, бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд урамшуулал, хөнгөлөлт, татаас, дэмжлэг үзүүлэх талаар бодлого, хөтөлбөр хэрэгжүүлээгүй, органик аж ахуйн үйл ажиллагаа, бүтээгдэхүүний талаар мэдээлэл цуглуулах, мэдээллийн санд бүртгүүлэх, мэдээлэл солилцох зэрэг үйл ажиллагаанд хамаарах эрх зүйн орчин бүрдээгүй, гарын авлага байхгүй зэргийг дурдаж болох юм. Иймээс экспортын баримжаатай органик үйлдвэрлэлийг хөгжүүлэхийн тулд үйлдвэрлэгчдийг дэмжих, органик бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, арга хэмжээний талаарх зохицуулалтыг хуульд шинээр нэмж тусгана.

8/ Түүнчлэн Органик хүнсний тухай хуульд заасан "органик", "байгалийн цэвэр", "байгалийн гаралтай цэвэр" гэх үг болон эдгээртэй агуулгын хувьд дүйцэх "эко", "ногоон", "экологийн гаралтай", "экологийн цэвэр", "экологийн", "био", "биологийн", "биологийн гаралтай", "биологийн цэвэр" гэсэн үгийг бүтээгдэхүүний шошгод ашиглан хэрэглэгчийг төөрөгдүүлэх явдал түгээмэл байгаатай холбогдуулан 5 эдгээр үг, хэллэгийг хуульд тусгах замаар хэрэглэгч болон органик үйлдвэрлэл эрхлэгчийн эрх ашгийг хамгаалсан зохицуулалт бий болгоно.

9/ Органик хүнсний тухай хуулийг зөрчил, давхардал, хийдлийн судалгаагаар тогтоогдсон хуулийн дотоод болон бусад хуулт тогтоомжтой зөрчил, давхардал, хийдлийг арилгаж, холбогдох өөрчлөлтүүдийг оруулна.

<sup>4</sup> Органик хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлангийн 2.1.2 дахь хэсгээс дэлгэрүүлэн үзнэ үү.

<sup>5</sup> Органик хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлангийн 2.1.4 дэх хэсгээс дэлгэрүүлэн үзнэ үү.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгмийн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээний талаар**

Хуулийн төсөл батлагдсанаар нийгэмд ямар нэгэн сөрөг үр дагавар гарагчай. Харин байгальд ээлтэй органик хүнсний үйлдвэрлэл эрхлэх эрх зүйн орчин боловсронгуй болсноор хөдөө аж ахуйн гаралтай органик бүтээгдэхүүний нэр төрөл нэмэгдэх, тогтвортой үйлдвэрлэл эрхлэх боломж бүрдэх, органик хүнсний хэрэглээг нэмэгдүүлэх, хуурамч бүтээгдэхүүнээс хэрэглэгч, үйлдвэрлэгчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчин сайжирна. Энэ нь хүн амыг эрүүл, аюулгүй, шим тэжээллэг дотоодын органик бүтээгдэхүүнээр хангах, Монгол Улсын органик хүнсний брэнд бүтээгдэхүүний экспорт нэмэгдэх, импортын бүтээгдэхүүнийг орлох чадвартай органик хүнс, хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд боловсруулах, үйлдвэрлэх, баталгаажуулах, хяналт тавих үйл ажиллагаа, түүнийг бүртгэх, хянах тогтолцоо тодорхой болохын зэрэгцээ энэ салбарт ажиллах боловсон хүчнийг бэлтгэх, үйл ажиллагааг урамшуулах, тогтвортой байдлыг хангах зэрэг асуудлыг шийдвэрлэснээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, органик аж ахуй эрхлэгчдийг дэмжих эрх зүйн орчин бүрдэнэ.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн эсэх, холбогдох хууль тогтоомжтой уялдсан байдал, хуулийн төслийг дагалдан гарах хууль тогтоомжийн төслийн талаар**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, холбогдох бусад хуультай нийцсэн болно. Гэхдээ органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг татварын бодлогоор дэмжих хэрэгцээ шаардлагыг үндэслэн Органик хүнсний тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай, Нэмэгдсэн өртийн албан татварын тухай, Ашигт малтмалын тухай, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай, Хүнсний тухай, Зөрчлийн тухай зэрэг хуулиадад нэмэлт, өөрчлөлт оруулна.

-оОо-